



Алтайн бүгд найрамдах улсын твшинд явагдсан “Газар дэлхий дэх цасны барс” наадам Горно-Алтайск хотод болж онгоров. Энэ арга хэмжээ 2010 оноос эхлэж, тус улсын муж, районууд болон тосгон суурингуудад ээлжлэн явагдаж ирсэн. Онгорсон долоон жилд, жил дараалан явагдсан уг арга хэмжээ нь тэр болгондоо сонирхолтой санаагаар баяжиж байсан ба хvvхдvvдийн бодол санааны биелэл нь бvжиг, зураг, дуу хогжим, театрчилсан тоглолтоор илэрдэг билээ. Оноо жилийн хувьд энэхvv “хvvхдvvдийн экологийн баяр” маань ер бусын вйл явдлаар эхэлсэн нь “Ирвэс аян” байлаа. “Ирвэс аян”-ны оролцогч хvvхдvvд бvгд найрамдах улсын нутаг дэвсгэрт хамаарах бvхий л муж районоос автобусаар хvрэлцэн ирэв. Ер бусын зорчигчидтой энэ аялалд хотын сургуулийнхан идэвхтэй хамрагдсан. Тэд ve тэнгийнхэнтэйгээ сонирхолтой яриа орнvvлцгээх нь “цасны муур” гэх гайхалтай амьтны тухайл байх агаад, “ондор ууланд амьдардаг энэ ховор амьтныг хамгаалахад бvс нутгийн оршин суугчид бултаараа хvчээ нэгтгэх хэрэгтэй” гэцгээх аж.ÂÂ “Ирвэс аян”-ынхан 10 сарын 13-ны одор Горно-Алтайск хотод хvрэлцэн ирцгээв. Тэдний хологлосон автобусууд Драмьн vндэсний теартын гол шатны дэргэд зогсож, буухиа наадмын “оргил арга хэмжээ” болох цасны барсд зориулсан шилдэг тоглолтонд (гала концерт) орцгоов. Оролцогчид маань театрын шатны гишгvvр дээрээс концертийг нээсэн ба нээлтэнд зориулан, барс хийгээд мануултай хамтдаа цоохор толбот

(
пятнистый тнец
)

хэмээх бvжиг бvжиглэцгээсэн юм.

Энэ удаагийн наадмыг Алтайн бvгд найрамдах улсын Байгалийн нооц, экологийн харилцааны яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Үйлдвэрийн орчин дахь мал, амьтныг хамгаалах улсын хороо Сийлхэмийн (Сайлюгем) vндэсний хvрээлэн (парк) болон Алтай, Катунь (Хада н гол)

байгалын нооц газрын хамтарсан “Газар дэлхий дэх цасны барс” тосол, Дэлхийн онгон байгалийг хамгаалах сан (WWF)

–аас хамтран зохион байгуулжээ. Наадмын арга хэмжээнд АБНУ-ын жаран дорвон суурингаас зургаагаас арван найман насны нийт гурван мянган хvvхэд багачууд хамрагдсан бол нийслэл хотод явагдсан тогсголийн шатны шалгаруулалт буюу “оргил арга хэмжээ”-нд бvс нутаг болон мужуудаас толоолсон нэг зуун хvvхэд мон тус

газруудаас насанд хврэгчдийн арван дорвон толоолол оролцов.



Үндэсний театрын үүдэн танхимд гэрэл зургийн болон, хvvхдvvдийн бүтээлийн вэсгэлэн дэлгэгдэв. Концертын нээлтийг внэхээр сонгодог тvвшинд явуулахаар нямбайлан бэлджээ. Дан байгалийн материалаар бүрдvvлсэн зохиомж, “барс л хамгаас чухал сэдэв” (ну а тема - барс) гэсэн бичиг бүхий цаасан майхан, цаасан тавгууд гээд, внэхээр гараа гаргаж бэлтгэсэн энэ зvйлсийг хvvхдvvд оорсдоо урлажээ.

Эцэст нь цасны барсын дүрстэй влэмж том ханын (адрын) чимэг зураг бүтээсэн ба тэрхvv дурсгалыг оролцогч хvvхдvvдийн гарын алган дээр буулган монхолсон юм. Зургийг бүтээхэд Горно-Алтайск хотын хvvхдийн уран зургийн сургуулийн хvvхдvvд багш нарын ур ухаан шингэсэн ба тэдний шилдэгvvдийн хамтын удирдлаган дор бүтсэн юм. Дэлхийн байгаль хамгаалах сангийн Алтай саяны салбарын хэвлэлийн нарийн бичгийн дарга Татьяна Иваничкагийн хэлснээр Непал улсын Дэлхийн байгаль байгаль хамгаалах сангийнхан энэ тухай мэдээллийг аваад ихэд талархан дэмжиж байгаагаа мэдэгдсэн ба

уулсын эх оронд оршин амьдардаг ирвэсээ хамгаалах энэ вйл хэрэг бол хамгийн чухал зорилт мон хэмээн санал нэгджээ. Оргил тоглолтын

(
гала концерт

)
нээлтэн дээр АБНУ-ын Байгалийн нооц, экологийн харилцааны яамны сайд Александр Алисов тэмдэглэн хэлэхдээ “АБНУ –д зохиогдож хэвшээд байгаа “Газар дэлхий дэх цасны барс” вйл ажиллагаанд оролцогчдын бүрэлдэхвүн жилээс жилд оргожин тэлж байна. Одоо ОХУ-ын нутаг дэвсгэрт цасны барсын

(
уулын ирвэс

)
ÂÂ

хамгийн том бвл, хэсэг нь оршин амьдарч байна. Энэ наадмын зорилго бол ховордсон амьтдыг хамгаалах вйл хэрэгт олон түмний анхаарлыг хандуулах явдал. Цаашдаа энэ вйл ажиллагаа маань манай тор засгийн болоод байгаль хамгаалах чиглэлийн байгууллагууд, мон орон нутгийн хвн амын гол зорилгын нэг байх ёстой. Бас энэ ажил бол манай орны хvvхдvvдийн нэг том гавъяат вйлс, бахархал гэж хэлэх байна” гэсэн юм.

Зохион байгуулах хорооноос энэ вйл ажиллагааы хврээнд “Шилдэг зураг”, “Шилдэг дурсгалын звйл (сувенер)”, “Талархалын ил захидал”, “Үлгэр” мон шинээр vvcгэсэн “Оршин суугчдын экологийн дврэм” гэсэн таван торол звйлээр бvх ve шатанд, нийтдээ 173 ажил зохион байгуулсан байна. Аяны эцэст уг уралдаанд оролцогсдын бvтээлvvдийг гурван насны ангиллаар шалгаруулан, шалгарсан тавин оролцогчид диплом, бусад шагнал гардуулсан бол багийн нийт оноогоор тэргvvлсэн Кош-Агач мужийн еронхий боловсролын дунд сургуулийнхан шилжин явах цомын эзэн болсон юм. Кош-Агаччууд энэхvv вйл ажиллагааг эхлэн санаачлагчдын нэг богоод 2010 оны тавдугаар сард анх удаа болсон “Газар дэлхий дэх цасны барс” наадмыг оорийн аймагт

(
район

)
амжилттай зохион байгуулж байсан билээ.

Дараа нь 2011 онд энэхvv экологийн наадам маань олон улсын чанартай болж, хорш Монгол улсаас хvvхдvvд ирж оролцсон. Зохион байгуулагч байгууллагаар “Алтайн тогтвортой хогжил сан”, “Амар тайван Укок” байгалийн хврээлэн, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Алтай, Саяны салбарууд хамтран ажиллаж байв. Оноодрийг хvртэл энэхvv буухиа арга хэмжээг улсын тvвшинд албан ёсны вйл ажиллагаа болгон хэвшvvлэхэд Сийлхэмийн

(
Сайлюгем

)
vндэсний хврээлэн зонхилон зvтгэж, гол vургийг гvйцэтгэсэн билээ. Яваа яваандаа энэ ажил маань хорш Тувагийн бvгд найрамдах улсад нэвтэрч, ажил хэрэг болж эхлэв.



Энэ онд гэхэд Буриадын бvгд найрамдах улсын Тvнх муж (Тункинский район) экологийн наадамд маань шинээр нэгдэн орлоо. Цаашилбал наадмын маань буухиа 10 сарын 23-нд Монгол улсын Улаангом хотод vргэлжилж, Улаангомьнхан анх удаагаа “Газар дэлхий дэх цасны барс” экологийн наадмыг орон нутагтаа зохион байгуулна.

Энд болсон наадам маань 10 сарын 23-ны олон улсын наадамтай нягт холбоотой. Тиймээ мэдээжийн хэрэг. Айсуу яваа хvйтэн овлийг дулаацуулам энэ сайхан вйл ажиллагаа маань зvй ёсоороо Алтайн бvгд найрамдах улсын нийслэлийн онцлогийг (брэнд) товойлгож чадлаа. Тиймээс жуулчид ч энэ арга хэмжээг сонирхон, зорьж ирж байхаар болов. Яг л Владивостокт болдог “Барын одор”, эсвэл манай Алтайн бvгд найрамдах улсын Мараль цэцгийн баяр

(
цветение Маральника

)

шиг. Горно-Алтайск хотын тов талбайд цасны барстай хамт, хогжилдон наадаж, ухаан,

авъяасаа уралдуулсан эл одрийг хотынхон маань дандаа санах нь магад.

Любовь ИВАШКИНА.

Орчуулсан Хиргис Г.ТӨРМӨНХ